

“Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн

2017 оны ээлжит хурлын тэмдэглэл

“Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурал 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10 цаг 30 минутанд Сүхбаатар дүүргийн 10-р хороо 7-р хороололд байрлах Барилгын дэвшилтэт технологийн төвийн 6-р давхрын хурлын танхимд эхлэв.

Хурлыг “Улсын их дэлгүүр” ХК-ийн Гүйцэтгэх захирал С.Сайнбат нээв.

Гүйцэтгэх захирал С.Сайнбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. “Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлын дэгийн дагуу тооллогын комиссын гишүүдийг сонгох болно. Хуралд оролцож буй та бүхнээс тооллогын комисст орж ажиллах хүн байвал өөрийн саналаараа оролцож болно. Миний саналаар тооллогын комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах саналтай байна. Саналын хуудас тоолох туршлагатай өмнө нь ажиллаж байсан учир “УИД” ХК-ийн нягтлан бодогч Д.Чимгээ, хуулийн ажилтан Н.Цагаанхүү, өөрийн саналаар тооллогын комисст ажиллах хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигч Б.Ганцэцэг гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр тооллогын комиссоо байгууллаа. Татгалзаж байгаа болон өөр саналтай хүн байна уу? /Хэсэг хүлээв / Өөр саналтай болон татгалзаж байгаа хүн байхгүй бол тооллогын комиссыг батлах уу? /бүгд гар өргөв/

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар хуулийн ажилтан Н.Цагаанхүү, гишүүдээр “УИД” ХК-ийн нягтлан бодогч Д.Чимгээ, хувьцаа эзэмшигч Б.Ганцэцэг нарыг томилов. Тооллогын комисс хурлын ирцийг нэгтгэн хуралд оролцож буй хувьцаа эзэмшигч нарт танилцуулав.

“Улсын их дэлгүүр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй 26,191,624 ширхэг хувьцаа буюу 71,16% -ийн хувьцааг эзэмшигчид, тэдгээрийн хуульд заасан шаардлагыг хангасан итгэмжлэгдсэн төлөөлөгчид хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул хурлыг хүчин төгөлдөрт тооцон хурлын үйл ажиллагаа эхлэв.

Хувьцаа эзэмшигчдын хурлын зар хүргэх тухай ТУЗ-аас гаргасан тогтоолд хурлын даргаар тус компанийн Гүйцэтгэх захирал С.Сайнбатыг томилсныг танилцуулаад хурлыг удирдан явуулахаар болов. Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдээс татгалзаж түдгэлзэж, санал гаргасан хүн гараагүй.

Хурлын дарга С.Сайнбат: Хурал эхэлснийг мэдэгдье. Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- 1) Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
- 2) Компанийн 2017 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцэл, түүнд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх
- 3) Компанийн ТУЗ-ийн 2018 оны зардлын төсвийг хэлэлцэн батлах
- 4) Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
- 5) Компанийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх талаар хэлэлцэн батлуулах

6) Өрийг хувьцаагаар солих талаар хэлэлцүүлэх

7) Бусад асуудал

Хурлаар хэлэлцэх асуудлуудын товч танилцуулгыг бид та бүхэнд урьдчилан хүргүүлсэн байгаа. “Улсын их дэлгүүр” ХК нь Монгол улсын хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй буюу 45,000 орчим хүнд 36 сая гаруй саналын эрхтэй хувьцаа тараагдсан том компани юм. Хувьцаа анх тарааж байх үед Эрдэнэтийн үйлдвэр ГОК-ийн хувьцаа эзэмшихийг хүссэн иргэдийг бөөнд нь “УИД” ХК-руу шилжүүлснээс ийм олон хувьцаа эзэмшигчтэй болсон юм.

/Компанийн Гүйцэтгэх удирдлагаас 2017 онд хийсэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг товч танилцуулав/ Нэгэнт танилцуулгаар хүргүүлсэн тодорхой тоон мэдээлэл агуулсан тайланг энд үг үсэггүй уншиж цаг алдахгүйн үүднээс та бүхэн товхимолтой танилцаад тодруулга болон асуулт асуух байдлаар тайлан, дүгнэлттэй холбоотой мэдээлэл авах хийх боломжтой юм.

Хувьцаа эзэмшигч Ж.Батсамбуу: Компанийн ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүнийг танилцуулна уу, мөн өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн хараат бус гишүүн хэн байна бэ, хараат бус гишүүний сонгон шалгаруулалт яаж хийгдээд байна бэ? Жижиг хувьцаа эзэмшигчид бидний төлөөлөлөөс яагаад ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгож ажиллуулахгүй байна бэ?

Хурлын дарга С.Сайнбат: “УИД” ХК нь ТУЗ -ийн 9 гишүүнтэй, үүнээс 6 энгийн, 3 нь хараат бус гишүүнээр ажилладаг. Өнөөдрийн хуралд ТУЗ-ийн дарга С.Хосбаяр, гишүүн А.Норсмаа, Б.Ариунжаргал, хараат бус гишүүн Д.Дашцэдэн нар хүрэлцэн ирсэн байна. Гишүүдийн танилцуулга та бүхэнд тараасан товхимол дээр бичсэн байгаа. Бид дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг 4 жилээр сонгодог бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулахдаа холбогдох хуульд заасны дагуу процессоор шалгаруулдаг бөгөөд 2016 онд ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгон шалгаруулж авахаар өдөр тутмын сонинд тавигдах шалгуурыг тусгасан зарыг нийтлүүлсэн боловч бидэнд жижиг хувьцаа эзэмшигчдээс хэн ч хандаагүй. Хууль, холбогдох дүрэм журамд зааснаар та бүхнээс шалгуураа хангасан хүн ороод ажиллах, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих боломж нээлттэй байгаа. Манай жижиг хувьцаа эзэмшигчдийн алдаатай тал бол жилд 1 л удаа зохион байгуулагддаг хувьцаа эзэмшигчийн хурал дээр ирчихээд маш их гомдол, санал, эсэргүүцэл үзүүлдэг боловч, өөрсдөө үүргээ биелүүлдэггүй, ядаж хуралдаа ирж суудаг хүн цөөхөн шүү дээ. Харин өнөөдрийн хуралд сэтгэл гарган ирж сууж байгаа та бүхэнд баярлалаа. Хувьцаа эзэмшигч Ж.Батсамбуу танд зөвлөхөд дараагийн сонгуульд идэвхтэй оролцоорой.

Хувьцаа эзэмшигч Ж.Батсамбуу: “УИД” ХК-ийн хөрөнгийн талаар мэдээлэл өгнө үү, одоо ямар үнэлгээтэй байдаг бэ? Үнэлгээ шинээр хийлгэсэн үү,

Хурлын дарга С.Сайнбат: “УИД” ХК-ийн барилгыг дахин үнэлүүлээгүй байгаа, бид үнэлгээ дахин хийлгэж болох боловч биднээс гарах үйлчилгээний хөлс, үл хөдлөх хөрөнгийн татвар зэрэг зардлын хэмжээ өсөх учир гүйцэтгэх удирдлага миний хувьд хувьцаа эзэмшигч та бүхэн зөвшөөрлөө өгвөл үнэлгээг шинэчлэн хийж болох юм. Мөн 1 зүйлийг хэлэхэд жил бүр хуулийн хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаж байгааг бүх хувьцаа эзэмшигчид мэдэж байгаа, тиймээс хэрвээ та бүхэнд хурлаар оруулаад шийдвэрлүүлчихээр асуудал байгаа бол хуульд заасан хугацаанд нь багтаж хурлын хэлэлцэх асуудалд санал оруулахаар ирүүлж болох юм. Гэтэл хурал дээр шууд хэлэлцэхээр асуудлыг хүлээн авах боломжгүй байдаг.

Хувьцаа эзэмшигч Б.Ганбаатар: Гүйцэтгэх захирлын тайлантай танилцлаа. Танилцуулгаар ирүүлсэн байгаа учир бидэнд ойлгомжтой байна, ТУЗ компанийг ашигтай ажиллуулах талаар цаашид ямар ажил төлөвлөөд байна бэ? Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах талаар хийхээр төлөвлөж байгаа ажлуудтай танилцмаар байна. Хувьцаа эзэмшигчдийн гол хүсэл нь компаниас ногдол ашиг авах хүсэлтэй байдаг, УИД ХК ногдол ашиг тарааж байсан эсэхийг би сайн мэдэхгүй байна. Хурлын хэлэлцэх асуудалтай холбогдуулаад танилцуулга дээр байгаа ТУЗ-ийн дүгнэлт ерөнхий байгаа учраас тодруулах зүйл байна, өнгөрсөн жилийн хугацаанд ТУЗ хэдэн удаа хуралдаж, хэдэн тогтоол гаргасан, ямар ажлууд хийсэн, гүйцэтгэх захирлын ажилд яаж хяналт тавьсан, цаашид компанийн засаглалыг сайжруулах талаар хийхээр төлөвлөсөн ажлыг ТУЗ-ийн даргаас тодруулга авмаар байна, мөн хараат бус гишүүдийн үүрэг оролцоог мэдэхийн тулд хараат бус гишүүнээр үг хэлүүлэх хүсэлтэй байна. Гүйцэтгэх удирдлага их дэлгүүрийн өнгө төрхийг засан сайжруулахад анхааран ажиллаж байгааг бид харж байна, түрээслэх талбайг нэмэгдүүлсэн, сүүлийн үеийн өнгө төрхөөр засан сайжруулсан зэргээр зардал гарган ажиллаж байгааг бид харж байгаа. Энэ их зардалд маш их мөнгө зарцуулж байгаа нь тодорхой байгааг ойлгож байна. Жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болон компанийн орлого зарлагад хяналт тавьж ажиллах хүсэлтэй байгаа учир ТУЗ-ийн гишүүнээр ажиллах хүсэлтэй байна.

Хурлын дарга С.Сайнбат: Таны асуултанд хариулт өгье. Хуралдаа ирж идэвхтэй оролцон санал шүүмжлэлээ хэлж байгаа танд баярлалаа. УИД ХК нь 2012 онд ногдол ашиг тараасан. Хурал болгон дээр би энэ талаар тайлбарлаад байгаа. Манай компанийн хувьд нэгж хувьцааны тоо маш их буюу 36 сая 800 мянга ширхэг хувьцаатай, бусад компанитай харьцуулахад тэдгээр компанийн хувьцааны тоо ширхэг бага учир ногдол ашиг тодорхой дүнгээр тараагдаад байдаг бол манайх нэгж хувьцаанд ногдох дүн маш бага байдаг учир цөөн тоотой хувьцаа эзэмшдэг хүмүүс маагь ойлгодоггүй, тухайлбал энэ жилийн ашиг болох 479 сая төгрөгийг нийт хувьцааны тоонд хуваахад нэгж хувьцаанд 13 төгрөг ногдоно, үүний манай хувьцаа эзэмшигчдийн дийлэнх болох 149 ширхэг хувьцаатай хүнийхээр бодоход 1,937 төгрөгийн ногдол ашиг оногдоно. Иймээс иргэд ногдол ашгаа авахаар очсон таксиныхаа ч мөнгийг төлж чадахгүй юм тараалаа гэж гомддог, хувьцаа гэдэг нь зөвхөн ногдол ашиг тараах бус зах зээл дээр арилжигдах үнэ өсвөл бидэнд хувьцаагаа худалдан борлуулах бас боломж бүрддэг.

2-р асуултын хувьд гүйцэтгэх засаглалын хувьд компани эрх бүхий албан тушаалтнууддаа тавигдах шаардлагаа тавиад ТУЗ хуулийн хүрээнд хурлаа хийгээд явж байгаа, энэ талаар ТУЗ дарга танилцуулах байх. Таны хувьд дараагийн сонгуулийн үеэр анкет танилцуулга хүсэлтээ ирүүлэх боломж бийг хэлье.

ТУЗ-ийн дарга С.Хосбаяр: Хүрэлцэн ирсэн та бүхэндээ баярлалаа. ТУЗ-ийн дарга С.Хосбаяр гэж хүн байна. ТУЗ-ийн үндсэн үүрэг бол компанийг стратегийн удирдлагаар хангах, хяналт тавих, тухайн жилийн бизнес төлөвлөгөөг батлах, санхүү тайлан балансад хяналт тавих зэргээр ажиллаж байна. Компанийн цаашдын стратегийн талаар танилцуулахаар тайлан бэлтгэгдсэн байгаа, энэ нь асуудлын дарааллаар яригдах учир давхцан ярих шаардлагагүй гэж бодож байна. Хувьцаа эзэмшигчид компаниас 2 үр өгөөж хүртэхийг хүсэж байгаа, түрүүн энэ талаар гүйцэтгэх захирал ярилаа, сүүлийн жилүүдэд компани ашиггүй ажиллаад байгаагийн нэг шалтгаан бидний үйл ажиллагаанаас

шалтгаалахгүйгээр валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан манай компани их алдагдалтай ажилласаар байсан. Өнгөрсөн жил компани ашигтай ажилласан боловч бид ногдол ашиг тараахгүй байх шийдвэр гаргасан нь дараах шалтгаантай байгаа. Үүнд Компанийн тухай хуулийн 48-д зааснаар компани ногдол ашиг тараасны дараа компани өөрийгөө санхүүжүүлэх чадвартай байх гэсэн шаардлагыг хангахгүй байгаа, мэдээж дараа дараагийн жилүүдэд ашигтай ажиллах боломжтой хувьцааны үнэ өсөж байгаа, өнгөрсөн жилүүдэд улс орон ч гэсэн хямралтай байсныг та бүхэн мэдэж байгаа, ирэх жилүүдэд эдийн засгийн байдал сэргэх боломжтой байгаа учир бид ашигтай ажиллах ногдол ашиг тараах чадвартай болно гэсэн хүлээлттэй байгаа юм. Сая та бүхний санал хүсэлтээс бид ТУЗ-ийн хурлаас гаргасан тогтоол, байнгын ажиллагааны талаар ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааны тайланг гарган хүргүүлж байя. Манай компанийн хувьд бүх хувьцаа энгийн хувьцаа байгаа болохоос бус давуу эрхийн хувьцаа байхгүй. Тиймээс том жижиг хувьцаа эзэмшигч гэсэн ойлголтоор ярих нь зөв юм. ТУЗ улиралдаа тогтмол хуралдаж байгаа, яаралтай асуудлаар ээлжит бусаар хуралдаж байгаа 10 гаруй тогтоол гарсан.

Хувьцаа эзэмшигч Ж.Батсамбуу: Бид хувьцаагаа зармаар байна, Том хувьцаа эзэмшигч нар худалдан авах боломж бий юу.

Хурлын дарга С.Сайнбат: Хувьцаа эзэмшигчийн хувьд брокер дилерийн компанид хувьцаагаа зарах захиалгаа өгөх боломж нээлттэй байгаа, иргэд үүнийг мэддэггүйгээс заавал компанидаа зармаар байна гэсэн ойлголт байх шиг байна.

Хувьцаа эзэмшигч Энхрийлэн /итгэмжлэлээр эцэг Жавхлан/: Таны тайланг сонслоо. Хувьцаат компаниудын талаар хувьцаа эзэмшигч бид өөрийн мэдлэгээ сайн өсгөх хэрэгтэй гэж уриалмаар байна. Тайлантай танилцлаа, миний хувьд ногдол ашиг авахаас илүү компанийн хувьцааны үнийг өсгөх талаар ажиллахыг хүсэж өөрийн саналыг оруулж байна. Хувьцааны үнэ өсөх нь эргээд бидэнд ашигтай худалдсан ч, миний саналаар бид хувьцаагаа барьцаалаад компаниасаа хүүтэй зээл авах боломжийг бүрдүүлэх зээл олгосны хүүгээр УИД ХК нь бас нэгэн орлого төвлөрүүлэх байдлаар ажиллах боломж бий юу. ТУЗ-ийн зардлыг нэмэгдүүлэхгүйгээр ТУЗ-ийн дэргэд энэ чиглэлийн ажлыг хийх, бизнес төлөвлөгөөг гаргахад туслахаар мэргэжлийн багийг ажиллуулах боломж бий бол тэр багт нь орон ажиллах хүсэлтэй байна. УИД ХК-ийг өдий зэрэгтэй авч явж байгаа удирдлагууддаа баярлалаа.

Хурлын дарга С.Сайнбат: Жавхланд баярлалаа. Зөв зүйтэй сайхан санал гаргаж байгаад, бид энэ талаар ТУЗ-д танилцуулна. Сүүлийн үед манай улсад энэ төрлийн нээлттэй зээл олгодог компаниуд үүсгэн байгуулагдаж байгаа. Хамтран ажиллах хүсэлт гаргаж байгаад баярлалаа.

Хувьцаа эзэмшигч : Ахмад настнуудад нэг удаагийн урамшуулал байдлаар тодорхой мөнгө өгөх боломжгүй юмуу.

Хурлын дарга С.Сайнбат: Саналаа хэлж байгаа та бүхэнд баярлалаа. Бид хуулийн дагуу ногдол ашиг тараах, хувьцааны үнэ өсгөх байдлаар нас байдлыг харгалзахгүй тараах л боломж бий.

Хувьцаа эзэмшигч Г.Цогоо: Хурлын материал эрт ирүүлсэнгүй. Ногдол ашиг тараах боломж байхгүй юмуу. ТУЗ гүйцэтгэх удирдлагад хяналтаа яаж тавьж байгаа бэ? Хэлэлцэх асуудлын дагуу дараах асуудлуудаа танилцуулна уу.

Хурлын дарга С.Сайнбат: Хурлын материалыг бид бүх брокер дилерээр тараасан байгаа, та бүхэнд хурлын материалтай танилцах эрх боломж нь байгаа, та бүхэн өөрсдөө танилцуулах боломж байгаа. Бидэнд тараасан бүртгэлийн жагсаалт байна. Монголын хөрөнгийн биржийн сайтад болон өдөр тутмын сонинд санхүүгийн тайлангаа байршуулж байгаа учир та бүхэн танилцах боломжтой байгаа. Одоо та бүхэнд хэлэлцэх асуудлын дарааллаар танилцуулга хийе.

Энэ асуудлыг Санхүүгийн зохицуулах хороо болон жижиг хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр хийгдэхээр төслийн хэмжээнд хийгдээд байгаа. Хуулинд заасны дагуу эдгээр асуудал нь ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэгдэх асуудал учир өнөөдрийн хурлаар оруулж байгаа юм.

/ Гүйцэтгэх захирал С.Сайнбат 4, 5-р хэлэлцэх асуудлын талаар танилцуулга хийв/

Хувьцаа эзэмшигч Ж.Батсамбуу: Халаасны хувьцаа гэж юу бэ?

Хурлын дарга С.Сайнбат: УИД ХК-ийн өөрийн эзэмшдэг хувьцаа юм.

Хувьцаа эзэмшигч Ж.Батсамбуу: Компани маань хуримтлалын сан үүсгэж болохгүй юмуу. Зээлээр бус хуримтлуулсан мөнгөөрөө зардлаа даагаад байх боломж байхгүй юу.

Хурлын дарга С.Сайнбат: Би энэ талаар ТУЗ-д танилцуулья. Эрсдэлийн сан байгуулах гэсэн санаа гэж ойлголоо.

Хувьцаа эзэмшигч Би Ди Сек ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Хишигбаяр: Манай компани 58,863 ширхэг хувьцааг эзэмшдэг, өрийг хувьцаагаар солих асуудлыг нэмж хувьцаа гаргах байдлаар шийдвэрлэх үү. Үүнтэй холбоотой үүсэх эрсдэлийг мэргэжлийн хүрээнд тооцоолол хийгдсэн үү, өрийг хувьцаагаар сольсноор хувьцааны төвлөрөл хэтэрхий 1 газар үүсэх вий гэсэн сэрэмжлүүлэг байна. Та бүхэнд хийсэн тооцоо судалгаа байгаа бол танилцуулна уу.

Хурлын дарга С.Сайнбат: Үнэт цаасны мэргэжлийн зах зээлд ажилаж байгаа хүний хувьд нилээн тодорхой нарийн асуултуудыг асууж байна. Энэ хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ асуудал дэмжигдвэл бид нэмж хувьцаа гаргах уу гэхчилэн асуудал тооцооллыг мэргэжлийн брокер дилер, андеррайтер, аудит, хуулийн компаниар хамтарсан тооцоолол судалгааг хийлгэнэ. Яагаад хурлын өмнө хийлгээгүй бэ гэхээр энэ ажиллагаа нь өөрөө маш их зардал шаардсан ажил учир бид өмнө нь хийлгээд зардал гаргачихдаг гэтэл ХЭХ-аар зөвшөөрөхгүй бол компаниас үргүй зардал гарахаас сэргийлэх үүднээс эхлээд хурлаараа оруулж шийдвэрээ гаргуулж байгаа юм. Энэ ажиллагааг хийснээр бидэнд давуу болон сул тал байгаа. Давуу тал нь зээлийн хүүний дарамтнаас ангижирна. Сул тал нь таны хэлснээр хувьцааны төвлөрөл хэт 1 газар үүсэх эрсдэлтэй юм.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Миний бие хөрөнгийн зах зээлд мэдээллийн чиглэлээр ажилладаг. Өрийг хувьцаагаар солих асуудлыг олон компани хийж байсан, тиймээс энэ нь магадгүй зөв шийдэл байх гэж бодож байна. Хувьцаа эзэмшигчид өөрсдөө мэдээлэл, мэдлэг маш муутай байна. УИД ХК-ийн мэдээллийг хөрөнгийн зах зээлд гаргахад туслах боломжтой. Мэдээллээ сайн гаргаж өгч байх хэрэгтэй байна.

Хурлын дарга С.Сайнбат: Хөрөнгийн зах зээлд энэ чиглэлийн ажил эрхэлдэг хувьцаа эзэмшигч байгаад нь баярлаж байна. Хамтран ажиллах боломжтой. Хурлын дэгийн дагуу цаг нилээн явсан байх тул та бүхэн өөр саналгүй бол хувьцаа эзэмшигчид та бүхэн тараасан саналын хуудсыг зааврын дагуу бөглөж хураалгана уу. Тооллогын комиссын дүн гартал засварлаж цай ууцгаана уу.

10 минут завсарлав.

Хурлын дарга С.Сайнбат : Тооллогын комиссын дүн гарсан байна. Дүнг танилцуулья.

Тооллогын дүнг уншиж танилцуулав.

За ингээд “Улсын их дэлгүүр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар дараах тогтоолыг баталж ээлжит хурлын үйл ажиллагааг дуусгах уу.

За та бүхэнд хуралдаа хүрэлцэн ирсэнд баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье гэснээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04-р сарын 27 ны өдрийн 13,00 минутад өндөрлөв.

Танилцсан: Хурлын дарга



С.Сайнбат

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Н.Цагаанхүү